

БАТЛАВ:

БОАЖЯ ХБОБНУГ-ЫН ДАРГА:

...../А.ЭНХБАТ/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ
ХҮЛЭЭСЭН

“ШИЛИЙН ЦАХАР” ХХК-ИЙН ЗАХИРАЛ:

...../Ч.ДЭЛГЭРЖАРГАЛ/



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ
БАЙРЛАХ ТӨМРИЙН ХҮДРИЙГ ХУУРАЙ
СОРОНЗОН АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: РР-900035/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР: 6171362/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн _____ /

Боловсруулсан:

“Шилийн цахар” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн  /Ч.Дэлгэржаргал/

Улаанбаатар хот

2022 он

Агуулга

1. Төслийн товч танилцуулга	2
1.1 Төслийн тухай товч мэдээлэл	2
1.2 Төслийн хүчин чадал, тоног төхөөрөмж.....	2
1.3 Баяжуулах үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт, бүтэц	2
1.4 Баяжуулах үйлдвэрийн удирдлага, зохион байгуулалт	3
1.5 Ажиллах хүч	4
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	4
2.1 Нийгэм эдийн засаг, дэд бүтцийн тодорхойлолт	4
2.2 Байгаль орчин	4
<input type="checkbox"/> Уур амьсгал.....	5
<input type="checkbox"/> Агаарын чанар	5
<input type="checkbox"/> Ус зүй	5
<input type="checkbox"/> Газрын доорх ус.....	6
<input type="checkbox"/> Хөрсөн бүрхэвч	6
<input type="checkbox"/> Ургамлан бүрхэвч.....	6
<input type="checkbox"/> Амьтны аймаг	7
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	8
3.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээ	8
3.2 Газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ	8
3.3 Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ.....	9
3.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ.....	9
3.5 Амьтны аймаг үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ.....	10
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	11
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
6. Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	15
7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15
8.Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
9. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	16
10. Хог хаягдлын менежмент төлөвлөгөө	17
11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	18
12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	19
13. Тухайн жилийн БОМТ, хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	19
14. БОМТ-ний 2022 оны төсөв.....	20

1. Төслийн товч танилцуулга

1.1 Төслийн тухай товч мэдээлэл

“Шилийн цахар” ХХК-ний төмрийн хүдрийг соронзон аргаар хуурай орчинд баяжуулах үйлдвэр нь газар нутгийн байршлаар Хэнтий аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт хамаарах ба Улаанбаатар хотоос 300км-т, Хэнтий аймгийн Дархан сумаас баруун урагш 35км, Бор-Өндөр сумаас баруун хойш 20км-т оршино.

Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр нь өөрийн эзэмшлийн орд болон хүдрийн нөөцгүй учир үйлдвэрийн хойд талд 1,5км зайд орших Баргилт-Овоо төмрийн хүдрийн ордоос 32-33%-ийн агуулгатай анхдагч хүдрийг сар бүр 50 мян.тн хэмжээгээр гэрээгээр худалдан авч баяжуулахаар төлөвлөсөн. Тус ордоос балансын төмрийн хүдрийг хуурай соронзон баяжуулалтын аргаар баяжуулан шууд экспортлох боломжтой баяжмал үйлдвэрлэнэ. Төсөл 5 жил үргэлжилнэ. Баяжуулах үйлдвэр жилд 500.0 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтай. Баргилт-Овоо ордоос баяжуулах үйлдвэр хүртэл хүдэр тээвэрлэлтийн ажлыг тээвэр зуучлалын компанитай гэрээ хийж тээвэрлүүлнэ.

1.2 Төслийн хүчин чадал, тоног төхөөрөмж

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал 500.0 мян.тн бөгөөд үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн ашиглалт 80-90%-тай ажиллах үед цагт 92.6 тн, хоногт 1852 тн хүрдийг ажлын 270 хоногт 24 цагаар баяжуулах хүчин чадалтай. Тус компани нь БНХАУ-ын “Shenyang shunda heavy mineral machinery manufacturing” ХХК-ийн бутлан ангилах, баяжуулах багц тоног төхөөрөмжүүдийг сонгон худалдан авч баяжуулах үйлдвэрийн талбай дээр угсарч суурилуулан үйлдвэрлэлийн туршилтын шатанд байна. Үйлдвэрлэлд CZW1149 маркийн чичиргээт тэжээгүүр, PEF0710 маркийн хацарт бутлуур, PYS-B1324 маркийн конусан бутлуур, PYS-D1306 маркийн конусан бутлуур, SZZ2200*6000 маркийн чичиргээт шигшүүр, ТВ1024 маркийн соронзон сепаратор, СТВ9018 маркийн соронзон сепараторууд үйл ажиллагаандаа ашиглана.

1.3 Баяжуулах үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт, бүтэц

Баяжуулах үйлдвэрийн байршлын ерөнхий төлөвлөлтийг баяжуулах үйлдвэрийн хэтийн төлөв, анхдагч хүдэр, баяжмал болон хаягдал хадгалах талбайн байршил, ажиллагсдын тосгоны амьдрах эрүүл ахуйн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зэрэг нөхцөлүүдийг үндэслэн гаргасан.

Баяжуулах үйлдвэр нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Түүхий эд буулган жигдрүүлэх талбай
- Хүдэр бутлан ангилан баяжуулах хэсэг

- Баяжмал хадгалах талбай
- Хаягдал овоолох талбай
- Авто пүүний хэсэг
- Засвар үйлчилгээний хэсэг
- Цахилгаан хангамжийн хэсэг
- Шатахуун түгээгүүр
- Хяналтын лаборатори
- Ажилчдын байр, контор

1.4 Баяжуулах үйлдвэрийн удирдлага, зохион байгуулалт

Хүний нөөцийн хувьд орон нутгийн ажилчдыг ажлын байраар хангах бодлогыг эхний ээлжинд авч үзэх ба орон нутгийн иргэдэд мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах, дадлагажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.

Баяжуулах үйлдвэрийн дарга үйлдвэрийн төлөвлөгөөт даалгаврыг хэрэгжүүлэх үүргийг компаний өмнө хүлээнэ. Баяжуулах үйлдвэрийн өдөр тутмын технологийн хэвийн ажиллагааг ээлжийн мастерууд хариуцна. Баяжуулах үйлдвэр дээр бутлуурын оператор, туузан дамжуулагчийн оператор, соронзосн сепараторын оператор, утгуурт ачигчийн оператор зэрэг мэргэжлийн бэлтгэгдсэн ажилчид ажиллана.

Ажлын зохион байгуулалтын ажлыг үйлдвэрлэлийн өмнөх ба үйлдвэрлэлийн үеийн хийгдэх ажлуудаар ангилна. Үйлдвэрийн өмнөх зохион байгуулалтад дараах ажлууд орно:

- Үйлдвэрийн захиргаа байгуулах, ажиллагсдыг элсүүлэх
- Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламж барих
- Хүдэр бэлтгэх талбай болон хаягдал овоолох талбай бэлдэх
- Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийг угсарч суурилуулах
- Цахилгаан шугам тавих, гэрэлтүүлгийн прожекторууд суурилуулах
- Тоног төхөөрөмжийн тохируулга хийх
- Дотоод дүрэм, журам, аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа ажлын байрны зааварчилгаа зэргийг боловсруулах, бэлтгэх
- Үйлдвэрлэлийн ажил явуулах үеийн ажлын зохион байгуулах үеийн арга хэмжээнүүд
- Үйлдвэрийн байгууламжийн ажил
- Үйлдвэрийн материал техникийн хангамж
- Ажлын богино хугацааны төлөвлөлт
- Засвар үйлчилгээ, үзлэг, тохируулга

1.5 Ажиллах хүч

Баяжуулах үйлдвэрийн ажилчдын материаллаг сонирхлын өндөрсгөх, ажиллагсдыг тоог нэмэгдүүлж, хөдөлмөрийн болон үйлдвэрлэлийн сахилга батыг бэхжүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж байна. Үйлдвэрийн ажиллах онцлог, ажлын нягтралыг харгалзан үзэж нийт 42 хүн ажиллана.

2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

2.1 Нийгэм эдийн засаг, дэд бүтцийн тодорхойлолт

Баяжуулах үйлдвэрийн ойролцоох төв суурин газрууд нь харилцаа холбоо өндөр хөгжсөн бүсэд хамаардаг. Үйлдвэр дээр үүрэн телефоны үндэсний байгууллага болох Мобиком, Жи Мобайл зэрэг сүлжээ ажилладаг.

Баргилт-Овоогийн уурхайгаас баяжуулах үйлдвэр хүртэл ердийн, орон нутгийн чанартай замаар холбогдсон ба тус уурхайгаас баяжуулах үйлдвэр хүртэл 1,4 км байна. Харин үйлдвэрээс гарах төмрийн баяжуулсан хүдрийг ойролцоо орших Бор-Өндөр сумын төв рүү зөөх ба энэ хооронд сайжруулсан шороон замаар холбогддог.

Баяжуулах үйлдвэр нь жилд 300 хоног ажиллах ба өвлийн улиралд ажиллагсадын тосгон, үйлдвэрийн захиргаа, гэр зэрэг барилга байгууламжуудын дулааныг нам даралтын бага оврын уурын зуухаар хангана. Уурын зуухны ажиллах сар нь зөвхөн хүйтний улиралд ажиллах буюу 11 дүгээр сарын 1-ээс 4 дүгээр сарын сүүл хүртэл буюу 6 сарын хугацаанд ажиллана.

Дархан сум нь 1956 оны 8-р сарын 1-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Баянмөнх сумтай нийлж, 1957 оны 8-р сарын 1-нд дахин бие даасан сум болон байгуулагджээ. Одоо Дархан сум нь засаг захиргааны 5 багтай, 2000 орчим хүн амтай, 189759 толгой малтай, 445482 га буюу 4454,8 км² нутаг дэвсгэртэй. Нутаг дэвсгэрийн хэмжээгээр аймгийнхаа 17 сумаас 7-р байранд ордог. Энэ нь аймгийн нутаг дэвсгэрийн 4,41%-ийг, Монгол Улсын нутаг дэвсгэрийн 0,28%-ийг тус тус эзэлдэг. Бор-Өндөрөөс 35 кв-ын цахилгаан дамжуулах шугамаар төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. Улаанбаатар-Чойр, Замын Үүдийн мянганы хатуу хучилттай зам нь нутгийн баруун талаар 100 км-ын зайтай өнгөрдөг.

2.2 Байгаль орчин

Төсөл хэрэгжих орчин нь геоморфологийн мужлалаар Хэнтий аймгийн уулархаг бүсийн зүүн урд төгсгөл Төв азийн их муж, Монгол Дорнодын мужын Улз, Хэрлэнгийн дэд мужид хамаарна. Байгалийн газарзүйн мужлалаар Хангай, Хэнтийн уулархаг их муж,

Онон Улз голын сав газрын хөмбөн-цулдан нам уул, хотгор, суурьт тал бүхий хээр, хуурай хээрийн муж, 10%-иас бага, мараа марз 10%-иас бага, бүхий умард хуурай хээрийн районд орно. Бүс бүслүүрийн хувьд хуурайсаг, үлдмэл бэсрэг нам уулс, толгод бүхий тэгшрэлийн гадарга зонхилсон, өндөрлөг тал юм.

➤ Уур амьсгал

Төслийн талбай уур амьсгал нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын шинжтэй. Энд өвөл нь хүйтэн бөгөөд удаан үргэлжлэх ба зун нь богино халуун болдог. Хавар намрын улиралд цаг агаар тогтворгүй, эрс өөрчлөгдөж байдаг. Жилийн дундаж хэм $-2-0^{\circ}\text{C}$ байна. Хур тунадас зуны саруудад унадаг бөгөөд нийт 150-200 мм хур тунадас унадаг байна. Дархан сумын нутаг нь хуурайдуу сэрүүн зунтай, хахирдуу өвөлтэй мужид хамаарах бөгөөд чийг хангамж 4,0, дулаан хангамж 2000-2500 байдаг.

Төслийн нутаг дэвсгэр орчоор манай орны бусад нутгийн нэгэн адил баруун, баруун хойд зүгээс салхи зонхилно. Бусад чиглэлийн салхи нь улирлын давтамжийн хувьд мэдэгдэхүйц хэлбэлзэл гардаггүй. Харин 4-11 дүгээр саруудад баруун урдаас зонхилон салхилах боловч түүний давтамж нь 5-14% байдаг. Салхины жилийн дундаж хурд 4-6м/с хүртэл хурдтай салхилж байсан байна.

➤ Агаарын чанар

Уг төслийн хувьд үйл ажиллагаа эхлээгүй байгаа хэдий ч төслийн талбайн ойр орчин дахь суларсан хөрснөөс тоос шороо хийсч агаарын чанарт нөлөөлдөг. Мөн түүнчлэн цаг агаарын эрс тэс байдал, салхины зонхилох чиглэлийн давтагдал, хурд, цасан ба шороон шуурга, хүчтэй салхи зэргийн нөлөөгөөр байгалийн гаралтай тоос шорооны бохирдол үүснэ.

➤ Ус зүй

Тус сум нь гадаргын усан хангамжаар муу, ихэвчлэн газрын гүний усыг ашигладаг. Гол мөрөн. Сумын хойд талаар баруунаас зүүн тийш өөрийн аймгийн Дэлгэрхаан сумтай 23 км-ээр хиллэн урсаж өнгөрдөг Хэрлэн гол байна. Сумын нутаг дэвсгэрт Дотуур булаг, Шавартай, Бор хужир, Далантүрүү, Бөөрийн булаг, Зараагийн гэээгийн булаг, Ходойн булаг, Бага булаг, Баянбулаг, Ноён булаг, Боонгын булаг, Дэвтээрийн булаг зэрэг тачир устай 31 булаг шанд байдгаас байгаль цаг агаарын хувьсан өөрчлөлтийн улмаас жил ирэх тутам ширгэн усгүй болсоор байна. Цайдам, Нарийн, Бүрд, Аман хужирын, Шар нуур, Хужирын хонхор зэрэг сумын хэмжээнд 17 нуур тойром байдгаас одоогийн байдлаар 9 нуур тойрмоос бусад нь ширгэн усгүй болсон байна. Тус сумын 2-р багийн нутаг Бөөрний рашаан, баруун Далантүрүүний рашаан, 3-р багийн нутаг Цахарын рашаан, Дархан

ууланд буй Дусалдаг, Дотуур булгийн рашаанууд нь ходоод, гэдэс, бөөр, мэдрэл зэрэг өвчнүүдэд сайн, нутгийн иргэд хэрэглэж ашигласаар иржээ. Мөн сумын хэмжээнд гүний, инженерийн, энгийн зэрэг 110 гаруй худаг уст цэг байдаг.

Төслийн нутаг дэвсгэр нь Хэрлэн голын сав газарт болон Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт багтдаг. Энэ сав газарт гадаргын усны гадаргын усны эх үүсвэр багатай бөгөөд голчлон зуны хур борооны дараах түр зуурын урсацтай горхиудтай. Улирлын чанартай гадаргын урсац нь жижиг нуур болон ширгэсэн давстай нуурын систем рүү цутгана. Зуны улиралд ширүүн салхитай бороо орсны дараа хуурай сайр, гуу жалгаар ширүүн урсгалтай үед үүсэж, ёроолын хагшаас, хурдсыг угааж, эвдрэл үүсгэдэг. Сав газрын ихэнх хэсэгт урсацын модуль $0,6\text{л/с км}^2$ -аас бага байдаг. Төслийн талбайн ойр орчимд гадаргын ил ус байхгүй бөгөөд урсацын модуль $0,6-1,4\text{л/с км}^2$, усан гадаргын ууршил $900-1100\text{мм/жил}$, нийлбэр ууршицын хэмжээ $690-700\text{мм}$ байна.

➤ Газрын доорх ус

Төслийн талбай нь Хөх усны (95) ай савд багтах ба энэ ай сав нь баруун талаараа Чойр, Дөрвөлжин овоотойн ай савуудтай ус хагалбарын шугамаар, өмнө талаараа Баастын талын өргөгдсөн захыг бүрдүүлж тогтсон неогений настай, ус үл нэвтрүүлэгч хурдсаар Дорноговийн ай саваар тусгаарлагдаж, Цайдам нуурын ай сав Хөх нуурын усны ай саваас дундлаг, хүчиллэг бялхмал чулуулгаас тогтсон Хажуу Улаан, Бор Өндөрийн уул толгодоор тус тус зааглагдаж байна.

Мөнххаан (66) Цайдам нуур (61) Хөх усны (95) нуурын ай савын хэмжээнд тархсан голоцений настай, хуурай эх газраар хүрээлэгдсэн түр нуурын түрэлт, таталтын явцад хуримтлагдсан хурдас дахь ус агуулагч бүрдэл тун багаас бага буюу $0,03\text{л/с}$ хэмжээнээс илүү гардаггүй устай байх тохиолдол элбэг.

➤ Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай, түүний орчим нам уул, ухаа-толгодын хүрэн хөрсний дэд хэв шинжид хамрагддаг хар хүрэн хөрс зонхилон тархах бөгөөд хотгор гүдгэрийн нөхцөл, хөрс үүсгэсэн чулуулгийн төрөл, тэдгээрийн илрэх гүн, ургамлын бүлгэмдэл зэрэг хөрс үүсгэврийн хүчин зүйлээс хамаарч энд тогтворжсон хөрс нь дутуу хөгжилтэй сайр чулуурхаг болон харилцан адилгүй зузаан ялзмагт давхаргатай төрөл, дүрсээс илэрнэ.

➤ Ургамлан бүрхэвч

Баяжуулах үйлдвэрийн орчимд үетэн хялганат, хазаар өвс, хиаг-хялганат, шарилж, лууль, дэрс, болон амт чанар шим сайтай үетэн, буурцагтан, алаг өвсний төрлийн ургамал зонхилно. Сумын хэмжээгээр үзвэл гол, булаг, нуур тойрмын хөвөөгөөр хиаг, хазаар өвс,

салхин ерхөг, дэрс, харгана, адамсын агь, хэрс зэрэг ургамал ургадаг ба сумын урд говтрхог талаараа таана, мангир, хөмүүл, ерхөг, үетэн, хялганат, алаг өвс, жижиг бутан үетэн, ботуульт ургамал зонхилон ургадаг байна. Сумын нийт бэлчээрийн 4,5% нь цэвэр бэлчээр, 59% нь сөөгт бэлчээр, 22% нь чулуурхаг бэлчээр, 14,5% нь довонтой бэлчээр байна. Эмийн ургамлаас юлдэн тарваган шийр, өргөст сарнай, нохойн хошуу, говийн ганга, таван салаа, царван, хөх дэгд, шар дэгд, цөс өвс, арц, банздоо, бошго, сөд, соргол зэрэг олон зүйлийн эмийн ургамал ургадаг.

➤ **Амьтны аймаг**

Төслийн талбайн орших газар нутаг Дархан сум нь агнуурын ан амьтны хувьд чоно, үнэг, хярс, бор туулай, дорго, хүрнэ, мануул, цагаан зээр, тарвага, зэрэг ан амьтан тааралдах ба сүүлийн жилүүдэд байгалийн хувьсан өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас тарвага, цагаан зээр зэрэг агнуурын ан амьтад эрс ховордсон байна.

Ховор ан амьтны хувьд төслийн талбайгаас 30 км зайтай орших Дархан ууланд 1980-аад оны эхээр буга, согоо, аргаль, угалз нутагшиж ирсэн ба ховор ан амьтны төрөлд орох гозоорой зурам нь мөн ууланд элбэг тааралдана. Аргаль угалз нь сүүлийн арваад жил Дархан уулаас Эргэнэг уул, Ноён Баян уул, Адагийн уулуудад тархан нутагшиж, тоо толгой нь өсөж байна. Одоогийн байдлаар буга 20 гаруй болж, аргаль хонины тоо толгой 200-д хүрчээ.

Махчин шувууд Дархан сумын нутаг дэвсгэрт бүх төрлийн бүргэд, шилийн сар, идлэг шонхор, начин шонхор, зээрд шонхор, тас, элээ, шар шувуу зэрэг шувуудаас гадна ховор шувуу болох ёл нь Дархан ууланд үзэгдэх болсон байна. Тус сумын нутагт Монгол улсын улаан номонд орсон нэн ховор Гангар хун, Хар тогоруу, Цэн тогоруу болон овогт тогоруунууд тааралдах ба Хэрлэн гол, нуур тойрмын хөвөө орчимд галуу, нугас, ангир, хун овогт тогоруу зэрэг усны шувууд элбэг байна.

3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

3.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээ

Төслийн агаарын чанарт үзүүлэх голлох сөрөг нөлөөлөл нь баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны үед хүдрийг ачиж буулгах, тээвэрлэх, овоолго хийх зэрэг технологийн үйл ажиллагааны явцад хуурай салхитай нөхцөлд тоос ихээр үүсч агаарыг бохирдуулна. Мөн хүнд даацын тээврийн хэрэгсэл болон бусад дотоод шаталтат хөдөлгүүр бүхий тоног төхөөрөмж, халаалтын зуухнаас ялгарах утаа нь агаар бохирдуулагч гол эх үүсвэр болно.

Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулахын тулд зам талбайг услах, тоосжилт дарах арга хэмжээнүүдийг авах, зам талбайг байнга тэгшилж бульдозер болон автогрейдерээр сул шороог хусч зайлуулах, хүчтэй салхи шуургатай үед газар шорооны ажлыг хязгаарлах, хийхгүй байх, эвдрэлд орсон газрын боломжтой хэсгийг нь тухай бүрд нь үржил шимт хөрсөөр бүрхэж ургамалжуулах зэрэг ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Хүдэр баяжуулах үйл ажиллагааны үед баяжуулах үйлдвэрийн бутлуур, шигшүүр, туузан дамжуурга зэрэг тоосжилтын эх үүсвэрүүдэд хаалт бүхээг, тоос сорох болон ус цацах төхөөрөмж суурилуулах, баяжуулах үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүнийг салхинд хийсгэхгүй байх хаалт хамгаалалт барих зэрэг ажлуудыг авч хэрэгжүүлнэ.

3.2 Газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Төсөл хэрэгжих талбайн орчинд гадаргын ус байхгүй. Харин төслийн унд ахуйн усны хэрэгцээг гүний худгаас хангах ба технологид ус ашиглахгүй. Тиймээс төслийн үйл ажиллагааны үед гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл байхгүй, газрын доорх усны нөөц чанарт үзүүлэх сөрөг нөлөө харьцангуй бага боловч ахуйн хаягдал бохир ус, шатах тослох материалын зохисгүй хадгалалт, тээвэрлэлт, зайлуулалтаас үүдэлтэйгээр газрын доорх ус бохирдож болзошгүй.

Төсөл хэрэгжүүлэгч нь усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгахын тулд ОХШХ-ийг тогтмол хэрэгжүүлэн төслийн усны эх үүсвэр болсон гүний худагт эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоож, дэглэмийг мөрдөж ажиллах, улиралд 1 удаа гүний худагт усны шинжилгээ хийлгүүлэх, техник хэрэгслийн тос масло, шатахуун алдагдахгүй байх нөхцлийг бүрдүүлэх зэрэг ажлуудыг төлөвлөн авч хэрэгжүүлнэ.

3.3 Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Баяжуулах үйлдвэр нь олборлолт явуулахгүй тул зөвхөн хүдэр зөөх, тээвэрлэх, буулгах үйл ажиллагааны үед газрын гадарга, хөрс нөлөөлөлд өртөнө. Иймээс газрын гадаргад үзүүлэх гол сөрөг нөлөө нь хүний үйл ажиллагаагаар бий болгосон зохиомол гадарга болох хог хаягдлын овоолго үүсгэх явдал юм.

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгахын тулд баяжуулах үйлдвэрээс гарах хог хаягдлыг байгалийн нөлөөгөөр эвдэрсэн, гуу жалгатай газрыг сонгон, орчны гадаргуутай ландшафтын хэлбэршлийн хувьд нэгдмэл бүтэц бий болгоход анхаарах, эсвэл хаягдал овоолгын огцом хажуу налууг сайтар хэлбэршүүлэн засч, техникийн нөхөн сэргээлтийг чанартай хийсний дараа шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай. Түүнчлэн овоолгыг тойруулан үер уснаас хамгаалах далан шуудуу байгуулах, олон салаа зам гаргахгүй байхаас гадна ашиглалтад өртөхгүй талбайг эвдрэлд оруулахгүй байхад анхаарах, шатах тослох материал нефтийн бүтээгдэхүүнээр хөрсийг бохирдуулахгүй байх, сэргийлэх үүднээс ШТМ-ын хадгалалт түгээлтэд онцгой анхаарч түүнийг асгарч алдагдахаас урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг тухай бүр зайлуулж, аль болох хур хог үүсгэхгүй байх, хөрсний хяналтын цэг дээр хяналт шинжилгээг тогтмол хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

3.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Үйлдвэр, хүдрийн овоолго, тээвэрлэлтийн зам болон бусад талбай дотор байрлах дагалдах байгууламжуудын доор өртөж буй хөрсний ургамлан нөмрөг устаж үгүй болно. Үүнээс гадна тухайн талбайн ойролцоох газрын ургамлан нөмрөг тоосонд дарагдах, машин техникийн нөлөөгөөр талхлагдах доройтох зэрэг сөрөг нөлөөлөлд өртөнө.

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, төслийн талбайн орчмын ургамлан нөмрөгийн доройтлыг багасгахын тулд шатах тослох материал, машин механизмын засварын газар болон ажилчдын тосгоны газрыг эмх цэгцтэй зохион байгуулах, орчныг бохирдуулахгүй байх талаар анхаарах, зам талбай, нөхөн сэргээсэн талбайн усалгаа тордолтыг чанартай хийх, ургамлыг доройтол бий болох магадлалтай газруудад хил хязгаар тогтоох, биологийн нөхөн сэргээлтийг байгалийн унаган төрхөнд аль болох ойртуулах, мод сөөг, олон наст ургамлын үр тарих, ингэхдээ “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS 5918:2008” стандартыг баримтлах, биологийн нөхөн сэргээлтэнд нутгийн унаган ургамал болон аль болох тухайн нутгийн онцлог тохирсон ургамлын сорт үрийг сонсон хэрэглэх, боломжит газруудад ногоон

байгууламжийг зохих арга технологийн дагуу байгуулах, тохижуулах зэрэг ажлуудыг хийнэ.

3.5 Амьтны аймаг үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Төсөл хэрэгжих талбайн ойр орчинд хүдэр ачих, зөөх буулгах зэрэг техник хэрэгслийн хөдөлгөөн, дуу чимээ ихэссэнээс амьтад улам дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх, амьдрах орон зай нь хязгаарлагдах зэрэг сөрөг нөлөө үзүүлнэ. Хүдэр буулгах талбай, хаягдлыг овоолгын талбай зэрэгт байршин амьдарч байсан жижиг мэрэгч, бичил биетэн зэрэг устаж үгүй болно. Мөн тэдгээрээр хооллодог хөхтөн, шувууд идэш тэжээлээ даган тэр орчноос холдоно.

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгахын тулд хууль бус агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад анхаарах, энэ талаар ажилчдад мэдлэг ойлголт бий болгох, шаардлагатай тохиолдолд амьтдыг устахаас хамгаалж өөр газар шилжүүлэх болон биотехнологийн арга хэмжээ авах талаар судалгаа хийх, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах, тээврийн зам дээр амьтан өнгөрөх гарц гаргах, саадгүй нэвтрэх боломжийг бий болгох, тэмдэг тэмдэглэгээ хийх, тоосжилтыг бууруулж хуурайшилт ихтэй үед зам талбайг услах, хатуу хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт, шингэн хаягдлыг ил задгай хаяхгүй зөвхөн бохирын цооногт зайлуулах ба амьтны бэлчээр, усанд ордог булаг шандын ойролцоо газар хаяхаас зайлсхийх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчин бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах үндсэн зорилготой.

Тус баяжуулах үйлдвэрийн төслийн БОННУ-д тусгасан Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах хууль, эрхзүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зүйл, заалтууд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын холбогдох шаардлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, тэдгээр эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллана.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэнэтийн осол эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүрээлэн буй орчин болоод нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж болох бүх талын арга хэмжээг авч эрүүл аюулгүй, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлж ажиллана. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамарсан.

Тус төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны орон зай, цаг хугацааг бүрэн хамарсан байхаас гадна байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээ зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгасан. Тухайн жилийн БОМТ-ний нийт төсөвт 12,9 сая.төг зарцуулахаар төлөвлөсөн.

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар						
1	Хүдэр болон ачиж буулгах, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх	Зам талбайг усалж чийглэх	Хүдрийн талбай овоолго	ҮАЗ	Үйл ажиллагаа идэвхтэй	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хөрсний эвдрэл нэмэгдэх, агаар дахь тоосны хэмжээ нэмэгдэх	Тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах тэмдэг байршуулах, сайжруулах, шинэ зам үүсгэхгүй байхад анхаарах	Дотоод зам	400,000	явагдаж байгаа болон хуурайшилын үед	MNS:4596:2007 Замын тэмдэг, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх журам

Хөрс газрын гадарга, газрын хэвлий						
1	Үйлдвэрийн барилга байгууламж, зам талбай доорх хөрс, газрын гадарга элэгдэлд өртөх	Боломжит хэсгүүдэд ногоон байгууламж, тохижилтын ажил хийх, сайжруулах	Үйлдвэрийн захиргаа, бусад орчин	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	Ургамал ургалтын хугацаанд	Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тариа арчлах
2	Үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас хөрс эвдрэх, үржил шим алдагдах бохирдох	Хөрсний дээж авч бүтэц, шинж чанарыг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасан хугацаанд тодорхойлуулах	Хяналтын цэгүүд	ОХШХ-т тусгасан		MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3	ШТМ-ын хагдлаар хөрс бохирдох	ШТМ-ын хадгалалтад хяналт тавих, ШТС, засварын цэгийн бетон хучилтыг сайржуулах		1,000,000		
Усан орчин						

1	Хур бороо, үерын усаар төслийн талбай дахь хог хаягдал, шатах тослох материалын үлдэгдэл угаагдан хөрсөнд нэвчиж улмаар газрын доорх усны чанар, найрлагад өөрчлөлт оруулж бохирдуулах	Шатах тослох материал алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон хог хаягдлын хадгалалтад тогтмол хяналт тавьж, асгарч алдагдсан тохиолдолд ашиглах шаардагдах хэрэгсэл, материалыг бэлэн байлгах	ШТС, засварын газар, хогийн цэгийн орчим	ОХШУ-т тусгасан	Үйл ажиллагаа идэвхтэй явагдаж байгаа болон хуурайшилын үед	Хог хаягдлын тухай хууль MNS5916:2008 Хог хаягдлыг ангилан ялгаж хаях журам
2	Усны шинжилгээг ОХШХ-т заасан хугацаанд хийлгэх			ОХШХ-т тусгасан		
3	Харъяа байгууллагатай ус ашиглах гэрээ байгуулах			ҮАЗ		
4	Нийт зардал			1,400,000		

6. Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал төг	Эрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Боломжит хэсгүүдэд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Ажилчдын суурин орчимд ногоон байгууламжийг сайжруулах	Цэцгийн мандал, нэг болон олон наст үрт ургамал, мод хөрсний онцлогт тохируулан тарих	1,000,000	5-6 дугаар сард
2	Тэр бум мод хөтөлбөр хэрэгжүүлэх	Мод тарих	500 ш тарьц суулгац тарих	2,000,000	
	Нийт зардал			3,000,000	

7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Орон нутгаас санал болгосон газарт MNS: 5914 стандартын дагуу техникийн нөхөн сэргээлт хийж, акт үйлдэн хүлээлгэж өгнө.

8. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжиж буй талбай, ойр орчинд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй байна. Цаашид ашиглалтын явцад түүх, соёлын өвтэй холбоотой олдвор, дурсгал илэрсэн тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

9. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Гэнэтийн осол	Анхны тусламжийн иж бүрдэл хүрэлцээтэй хэмжээгээр бэлтгэх		Үйл ажиллагаа тогтмол явж байх үед	
	ХАБЭА-н сургалтуудыг тогтмол зохион байгуулах			
	ШТМ асгаралтын үед ашиглах шингээгч материал			
Гал түймэр	Галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх журам боловсруулж, мөрдөж ажиллах			
	Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл хүрэлцээтэй хэмжээгээр байрлуулах, галын хорны даралт, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах			
Эрүүл мэнд	Гэнэтийн ослын даатгал, ЭМҮ-т хамруулах	Гэрээний дүнгээр		
Нийт зардал		ХАБЭА-н зардлаас		

10. Хог хаягдлын менежмент төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал төг	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Ахуйн	Хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөр хураамжийг цаг тухайд нь төлөх	2,600,000	Хог хаягдлын тухай хууль, ангилан ялгаж хаях журам, дотоод дүрэм журам
2		Хог хаягдлын цэг болон бохирын цооногт ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	100,000	
3		Ахуйн хатуу хог хаягдлыг орон нутгаас заасан цэгт тээвэрлэн зайлуулах		
4		Ашигласан тос маслыг бүртгэж, Техникийн ашигласан тос боловсруулдаг ААН-д нийлүүлэх		
5	Ахуйн	Хатуу хог хаягдал ангилан ялгах сав, хаяг самбар нэмэх	800,000	
Нийт зардал			3,500,000	

11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаар				
1	Тоосжилт (PM10, PM2.5)	Хяналтын цэгт	Жилд 2 удаа	MNS 4585:2007 агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага
Хөрс				
2	Хөрсөн агуулагдах бохирдуулагч хүнд металын шинжилгээ	Хяналтын цэгт	Жилд 2 удаа	MNS 5850:2019 Хөрс бохирлуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Усан орчин				
3	Ундны усны ерөнхий химийн шинжилгээ	Ажилчдын хотхоны худаг	Улирал бүр	MNS 0900:2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ
4	Ахуйн бохир ус	Ажилчдын хотхон	Улирал бүр	MNS 6561:2011 ариутгах татуургад нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага.
Тухайн жилийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төсөв				2,000,000

12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцагч
1	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилчдын дунд сургалт зохион байгуулах	1-3 дугаар улиралд	ХАБЭА-н төлөвлөгөө
2	Байгаль орчны хуваарьт аудит хийлгэх	I улирал багтаан гүйцэтгүүлнэ	Байгаль орчны мэргэжилтэн
3	Газар, ус, агаар бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулах	Жилийн эцэст төлж барагдуулсан байх	Гүйцэтгэх захирал, Ня-бо

13. Тухайн жилийн БОМТ, хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов
1	Багийн ИТХ-д	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт гүйцэтгэл Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний талаар мэдээллэ	3 дугаар улирал
2	Засаг даргын тамгын газар		
3	Нөлөөлөлд өртөгч оршин суугчид		

14. БОМТ-ний 2023 оны төсөв

№	Төлөвлөгөө	Төлөвлөсөн зардал
1	Сөрөг нөлөөллийн буруулах арга хэмжээний биелэлт	1,400,000
2	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ХАБЭА-н зардал
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,500,000
4	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,000,000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,000,000
6	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	3,000,000
7	Тэр бум мод	2,000,000
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв:		12,900,000

**ҮЙЛДВЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хянасан огноо	
Хянасан мэргэжилтэнгүүдийн хувийн дугаар	
Дүгнэлт	
<ul style="list-style-type: none"> • Шийдвэрийн төсөл • Ололт, амжилттай тал • Дутагдалтай сул тал • Шаардлага 	

**НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД,
ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.

• Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг “*хамааралгүй*” гэж бөглөнө.

• 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн нөхнө сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Шилийн Цахар” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9019084040
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Хүдрийн баяжуулах үйлдвэр
	4. Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг	ХЭА Дархан сум 2-р баг
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	А.Элбэгсайхан 99096800
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Ч.Дэлгэржаргал 99918876
1.2	1. Төслийн нэр	Төмрийн хүдэр хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэр
	1. Төслийн харъяаллын байршил	ХЭА Дархан сум 2-р баг
	3. Төслийн ангилал	Үйлдвэр
	4. Төсөл эхэлсэн огноо	2018 он
	5. Төсөл хэрэгжих хугацаа	5 жил
	6. Үйлдвэрийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлт	
	7. ТЭЗҮ баталсан огноо	2018 он
	8. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	Үйл ажиллагаа явуулаагүй

**ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ,
ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- Тусгай зөвшөөрөл, үнэлгээ, дүгнэлтийг баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
 - Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
2.1	1. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	Хамааралгүй
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах, тэсрэх дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дагуу олгосон холбогдох зөвшөөрөл бусад баримт бичиг/ Дугаар Хүчинтэй хугацаа	Хамааралгүй
	3. Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт	Хамааралгүй
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	2022.05.19- 2024.05.19 № 0003086
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2018.6.11 Д.Тэмүүлэн
	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2019 он Ерөнхий шинжээч А.Энхбат
	7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	Үйл ажиллагаа явуулаагүй
	8. Тухайн жилийн батлагдсан үйлдвэрлэлийн төлөвлөгөөний огноо	
	9. Тухайн жилд баримтлаж ажиллах стандартын дугаар <ul style="list-style-type: none"> • Үндэсний Олон улсын 	MNS 5850 2019 MNS 0900 2018 MNS 6561 2015

ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2 дугаар хавсралтанд тусгагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заагдсны дагуу химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох доорх мэдээллийг оруулах

- Тухайн жилд химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хавсралтаар оруулж хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах /хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай/

- Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт **“хангалттай”** гэсэн дүгнэлтийг оруулна.

- урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- эрсдлийн үед авах арга хэмжээ
- учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ
- хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ

- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тухайн жилд гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдлыг хэрхэн устгах, зайлуулах арга хэмжээ, давтамж, мониторингийн арга хэмжээг тусгах, хуванцар, резинен материал /дугуй, сав баглаа боодол/ зэрэг хог хаягдлыг дахин ашиглах цэгт хүргэх хуваарь, аюултай хог хаягдлыг хадгалах агуулах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/ химийн бодис, бүтээгдэхүүнээс гарах сав баглаа боодлын хэмжээ	Химийн бодис ашиглахгүй
	2. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	Хамааралгүй
3.2	1. Шатах тослох материалын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	ШТМ-ын агуулах-түлш байхгүй
	2. Тэсрэх, дэлбэрэх бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	
3.3.	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ <ul style="list-style-type: none"> • Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ • Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ • Аюултай хог хаягдал 	Зтн
	2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	3.500.000 төгрөг

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ

- Доорх хүснэгтийн 4.12 - 4.1.7 –д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1 –д тусгагдана.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	12,900,000 төг
	2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	1,400,000 төгрөг
	3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв	3,000,000
	4. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	
	5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	
	6. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	2,000,000 төгрөг

ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

• Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.

• Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах багана
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл <ol style="list-style-type: none"> 1. Ажилчдын байр, оффис 2. Дэд бүтэц (зам, өндөр хүчдэл, цахилгаан сүлжээ, шугаман хоолой, станцын байршил, хашаа, тусгаарлагч, үерийн хамгаалалтын далан, аянга зайлуулагч гэх мэт) 3. Хог хаягдлын цэгийн байршил 4. Хог хаягдлын агуулахын байршил 5. Хог хаягдлын далан 6. Химийн бодисын агуулахын байршил 7. Орчны хяналт шинжилгээний дээж авах хяналтын цэгийн байршил 8. Гүний худгийн байршил 9. Дүйцүүлэн хамгааллын байршил 	

ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэхь багананд “**тодорхойлсон**”, “**тодорхойлоогүй**” “**хамааралгүй**” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.

- Дүгнэлт гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнийн нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэрэгжилтэн дүгнэлт гаргана.

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөл-лийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
6.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
6.2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
6.3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
6.4. Агаарт үзүүлэх нөлөөлөл	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	

ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх
- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “**Тийм**”, “**Үгүй**” хариулт өгнө.
- Доорх хүснэгтийн “Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, ногоон хөгжлийн мэргэжилтэнүүд “**хангалттай**” “**хангалтгүй**” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
6.1. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	6	Тийм	Тийм	
6.2. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ -техникийн/ га эзэлхүүн -биологийн /га				
6.3. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ		Тийм	Тийм	
6.5 Төслийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	1	Тийм	Тийм	

НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А, Б, В, Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж	Г. Төсөв
Хөрс	1	Овоолго Үйлдвэрийн талбай	1	800.000 төгрөг
Ус	1	• кемпийн худаг	1	800.000 төгрөг
Амьтан				
Ургамал				
Агаар	1	Овоолго Үйлдвэрийн орчин	1	400.000 төгрөг



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАРХАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА**


Мэргэн хошуу баг, Дархан сум, Хэнтий аймаг, 23180
Утас/Факс: 70-08-56-00
Цахим шуудан: darhansum01@gmail.com

2022.11.22 № 1/336

танай _____-ны № _____-т

Тодорхойлолт

“Шилийн цахар” ХХК /РД:6171362/ нь Хэнтий аймгийн Дархан сумын нутагт төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэрлэл явуулдаг бөгөөд 2022 онд Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан боловч Цар тахлын хорио цээрийн улмаас Эрээн хотоор задгай ачаа нэвтрүүлэхгүй байгаа учир Шилийн цахар ХХК нь төлөвлөгөөт онд үйл ажиллагаа явуулаагүй нь үнэн болно.



Ж.ЭНХТӨР



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАРХАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА**

Мэргэн хошуу баг, Дархан сум, Хэнтий аймаг, 23180

Утас/Факс: 70-08-56-00

Цахим шуудан: darhansum01@gmail.com

Бод. 11.22


№

1/339

танай _____-ны № _____-т

Тодорхойлолт

“Шилийн цахар” ХХК /РД:6171362/ нь Хэнтий аймгийн Дархан сумын нутагт төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэрлэл явуулдаг бөгөөд 2022 онд Ашиглалтын үйл ажиллгааны төлөвлөгөө болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан боловч Цар тахлын хорио цээрийн улмаас Эрээн хотоор задгай ачаа нэвтрүүлэхгүй байгаа учир Шилийн цахар ХХК нь төлөвлөгөөт онд үйл ажиллагаа явуулаагүй нь үнэн болно.



Ж. ЭНХТӨР

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
 Журналын /Journal No: 4722899

Системийн огноо/System Date: 2022/06/17

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дун/Amount	Ханш/Rate
	5753644125	ХАТАГАЙ ЖИГЖИДСҮРЭН ОЮУЛЖАРГАЛ	6,450,000.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No MORUMNUB	Банкны нэр/Bank Name Төрийн Сан		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 100900013406	Нэр/Name БО нөхөн сэргээх баталгаа	6,450,000.00 MNT	1.00

 Гүйлгээний утга/Transaction description:
 шилжйн цахар хаяг 6171362


Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:



Санаамж: Бага дүнтэй (Таван сая төгрөг хүртэлх дүнтэй) гүйлгээ тухайн данс руу шууд шилжих бөгөөд таван сая төгрөгөөс дээш дүнтэй үед хүлээн авагчийн нэр, данс зөрвөл таны данс руу буцан орно. Амжилттай гүйлгээний баримт таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу илгээгдэнэ. Ажлын өдрийн 16:00 цагаас хойш болон амралтын өдөр таарсан их дүнтэй (таван сая төгрөгөөс дээш дүнтэй) гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдэхийг анхаарна уу